


ИНФОГРАФИК: ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт





ЭКСПОРТЫН ГОЛ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭМЖЭЭ БОЛОН ДУНДАЖ ҮНЭ

Экспортын гол бүтээгдэхүүний хэмжээ болон дундаж үнийг графикаар оны эцсийн байдлаар харуулав.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ИНФОГРАФИК- САР ТУТМЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД



ЭДИЙН ЗАСАГ ЯМАР БАЙХ ВЭ?- ТААМАГ (ОУЭЗБ)

ДНБ-ий өсөлт: 2019 онд: +6.7%, 2020 онд: +6.1%
Инфляци: 2019 онд: +8.5%, 2020 онд: 7.5%

Урсгал тэнцэл: 2019 онд: ДНБ-ий -9.6%, 2020 онд: -13%-тай байхыг Азийн хөгжлийн банк (АЗХБ) 2019 оны тайланд тоймлосон байна.

ДНБ-ий өсөлт: 2019 онд: +6.3%
Инфляци: 2019 онд: +7.1%,


ДНБ-д эзлэх урсгал тэнцэл: 2019 онд: -10.8%- Олон улсын валютын сан (ОУВС)-аас гаргадаг (Дэлхийн эдийн засгийн төлөв байдлын судалгаа, 2019 он) тайланд дурдсан байна.

Эх сурвалж: <http://bit.ly/2zsmvYo>

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД: УЛСЫН ТӨСӨВ, ВАЛЮТЫН ХАНШ, ИНФЛЯЦИ, ГАДААД ХУДАЛДАА

Төсвийн тэнцэл 12-р сарын байдлаар 627 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

Улсын нэгдсэн төсвийн орлого өмнөх жилийн мөн үеэс 17 хувиар, зарлага 23.9 хувиар тус тус нэмэгдсэн бол төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 627 тэрбум төгрөгийн алдагдалтай гарав. Төсвийн алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 747 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.



Ам.долларын ханш өмнөх сараас 22 төгрөгөөр өсөв.

Арванхоёрдугаар сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс 89.9 төгрөг буюу 3.4 хувиар нэмэгдэж, өмнөх сартай харьцуулахад 22 төгрөг буюу 0.8 хувиар, өмнөх улирлаас 2.1 хувиар өсч 2727.34 төгрөг болов. 11-р сард гадаад валютын нөөц 4 тэрбум төгрөг буюу өнгөрсөн сараас 0.4 хувиар буурч, өмнөх оны мөн үеэс 15.2 хувиар, оны эхнээс 13.1 хувиар тус тус өсөв.




Инфляцийн түвшин 5.2%

Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2019 оны 12-р сарын байдлаар өмнөх сараас 0.6 хувиар буурч, өмнөх оны мөн үеэс 5.2 хувиар, оны эхнээс 5.2 хувь өсөв. Ингэж өсөхөд хүнсний бараа, согтууруулах бус ундаа, хувцас, бөс бараа, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний өссөн нь голлон нөлөөлжээ.



Гадаад худалдааны тэнцэл 1492 сая.ам доллар болов.

2019 оны арванхоёрдугаар сард нийт барааны эргэлт 13747 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 6.6 хувиар өссөн бол экспорт өмнөх сараас 8.6, импорт өмнөх оны мөн үеэс 4.3 хувиар өсч гадаад худалдааны тэнцэл 1492 сая ам.долларын ашигтай гарчээ.



12-Р САРЫН ОНЦЛОХ: МОНГОЛ УЛСЫН НИЙТ ГАДААД ӨР

Эх сурвалж: www.mongolbank.mn

2019 оны гуравдугаар улирлын байдлаар Засгийн газрын нийт гадаад өр 7.3 тэрбум ам.доллар, Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 29.9 тэрбум ам.доллар болсон байна. Энэ нь өмнөх улирлаас 3Г-ын өр 2% (127.5 сая ам.доллар)-иар өссөн бол, Улсын нийт гадаад өр 1% (240 сая ам.доллар)-иар өссөн байна. Харин төв банкны өр 4% буюу 86 сая ам.доллараар буурсан бол хадгаламжийн байгууллагуудын өр 2% буюу 35.9 сая ам.доллараар тус тус буурчээ. Нийт гадаад өрийн 25%-ийг засгийн газрын өр, 7%-ийг Төв банкны өр, 7%-ийг хадгаламжийн байгууллагуудын өр, 29%-ийг бусад салбаруудын өр, 33%-ийг компани хоорондын зээллэгийн өр тус тус эзэлж байна.

САРЫН ОНЦЛОХ

ГАЗРЫН ТОСНЫ ОЛБОРЛОЛТ

- Улсын хэмжээнд энэ онд нийт 8.15 сая баррель буюу 1.1 сая тн газрын тос олборлон экспортод гаргаад байна. Газрын тосны олборлолтоос улсын төсөвт 335.6 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэх төлөвлөгөөтэй. Үүнээс энэ 12 дугаар сарын 4-ний байдлаар улсын хэмжээнд 6.39 сая баррель буюу 867.1 мян.тн (78.47 хувь) газрын тос олборлож, 6.09 сая баррель буюу 827.7 мян.тн (74.79 хувь) газрын тос экспортолж 12 дугаар сарын 15-ны байдлаар 210.2 тэрбум төгрөг (62.6 хувийн)-ийн орлого хуримтлуулаад байна.

УУЛ УУРХАЙ, АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРААС УЛСЫН ТӨСӨВТ ОРУУЛСАН ОРЛОГО

- Уул уурхай, аж үйлдвэрийн салбараас улсын төсөвт оруулсан орлого 2.4 их наяд төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулахад 518.6 тэрбум төгрөг буюу 26.7 хувиар өссөн дүнтэй байна. Үүнээс: Нүүрс 1.1 их наяд төгрөг, зэс 981.7 тэрбум төгрөг, алт 112.5 тэрбум төгрөг, цайр 65.2 тэрбум төгрөг, төмөр 24.5 тэрбум төгрөг, жонш 29.9 тэрбум төгрөг, бусад орлого 69.5 тэрбум төгрөг. Өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулахад нүүрс 3.50 сая.тн буюу 7.9 хувь, төмрийн хүдэр 2.20 сая.тн буюу 37.4 хувь, хайлуур жоншны хүдэр 33.2 мян.тн буюу 33.8 хувь, газрын тос 539.8 мян.баррель буюу 9.3 хувиар тус тус өссөн байна. Харин зэсийн баяжмал 33.2 мян.тн буюу 2.8 хувь, алт 4.4 тн буюу 22.9 хувь, молибдений баяжмал 266.5 тн буюу 5.3 хувь, төмрийн хүдрийн баяжмал 94.5 мян.тн буюу 3 хувь, хайлуур жоншны баяжмал 25.9 мян.тн буюу 38.1 хувь, цайрын баяжмал 1.8 мян.тн буюу 2.3 хувиар тус тус буурав.

Эх сурвалж:

- Статистикийн бюллетень, 12-р сар 2019 он, Үндэсний статистикийн хороо
- Статистикийн бюллетень, 12-р сар 2019 он, Монголбанк
- www.1212.mn, www.mongolbank.mn, www.montsame.mn